

2022 оны зэргийн шалгалтын бүртгэл хийх тухай
(Ахлах зэрэг)

2022-01-28

1. Бүртгэлийг цахимаар буюу **Google Forms** ашиглан бүртгэл хийнэ. Иймд эмч бүр өөрийн **gmail** хаягтай байх шаардлагатай ба өөрийн gmail хаягаар орж бүртгүүлнэ.
2. Материалыг бэлнээр хүлээн авахгүй.
3. Бүртгэл 2022 оны 2 сарын 1-нээс 15-ны өдрийн 17 цаг 00 минут хооронд явагдана. (бүртгэлийн холбоосыг 2022-01-31-нд зарлана)
4. Холбогдох материалуудыг **сканердаж** хавсаргана. Үүнд:
 - 4.1. Иргэний үнэмлэхний хуулбар (зөвхөн нүүр тал)
 - 4.2. Мэргэшлийн дипломын хуулбар (резидент төгссөн диплом)
 - 4.3. Эмчлэх эрхийн лизензийн хуулбар
 - 4.4. Мэргэшлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол шийдвэр, үнэмлэхний хуулбар
 - 4.5. 3*4 хэмжээний фото зураг (сүүлийн 6 сар доторх)
 - 4.6. НДД-ийн хуулбар (эхний зурагтай болон сүүлийн бичлэг бүхий хуудас
5. Мэргэшлийн зэргийн шалгалтанд орохыг хүссэн хувийн өргөдөл (ЭМХТ-ийн цахим хуудсанд байгааг татаж авч бөглөнө)
6. Байгууллагын даргын баталгаажуулсан мэргэшлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн маягт (ЭМХТ-ийн захирлын шийдвэрээр батлуулсан загвараар, ЭМХТ-ийн цахим хуудсанд байгааг татаж авч бөглөнө, сканердэж хавсаргана.)
7. Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас дэмжсэн тодорхойлолт (сканердаж хавсаргана)
8. Биелүүлсэн багц цаг. (2017-2019 оны жил тутмын 6 багц цагийн 2/3 нь эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр байх) Гэрчилгээнүүдийг сканердаж хавсаргана.
9. **“Ахлах”зэргийн тусгай шаардлагыг хангасныг баталгаажуулах баримт бичгүүд.** Үүнд:
 - 9.1. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг мэс засал, ажилбаруудын техникийг эзэмшсэн байх (кесар мэс засал, умай өндгөвч дайврын хоргүй хавдар, умай гадуурх жирэмсэн болон умайгаас зангилаа авах зэрэг). Ажлын тайлангаар баталгаажуулах ба тайланг хавсаргана.

- 9.2. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх (тайлангаар баталгаажуулах ба тайланг хавсаргана)
 - 9.3. Оношилгоо эмчилгээний шинэ техник, аргачилал 2-оос доошгүйг эзэмшсэн байх (нэр, он бичих, хувилж хавсаргах)
 - 9.4. Байгууллагынхаа түвшинд оношилгоо, эмчилгээний гарын авлага, зөвлөмж 2-оос доошгүйг боловсруулсан байх (гарчиг, нүүр, нэр оролцсон хэсгийг хувилж хавсаргах)
 - 9.5. Эзэмшсэн мэргэжлээрээ судалгааны ажил 1-2 удаа хийж, онол практикийн хуралд хэлэлцүүлсэн байх (гарчиг, нүүр, нэр оролцсон хэсгийг хувилж хавсаргах)
 - 9.6. Нийтэд болон үйлчлүүлэгч нарт зориулж мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж, санамж 2-оос доошгүйг бичиж сонин, сэтгүүлд хэвлүүлсэн буюу радио, телевизээр нэвтрүүлсэн байна. (сүүлийн 3 жилийн ажлын баталгаажсан тайлан)
10. МЭБЭЭНХ-ны татвар (сүүлийн 3 жилийг тушаасан баримт, сканердаж хавсаргана)

МЭБЭЭНХ